

**БУЛАГ, РАШААНЫ ЭХИЙГ ХАШИЖ ХАМГААЛАХ, ТОХИЖУУЛАХ  
АЖЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

2019.02.19

Хэрлэн сум

**Байршил:**

1. Дашбалбар сум Энгэрийн булаг /сумын төвөөс зүүн хойш 30 км/
2. Гурванзагал сум Гурваны булаг /сумын төвөөс зүүн хойш 32 км/
3. Сэргэлэн сум Энгэрийн булаг /сумын төвөөс хойш 50 км /
4. Хөлөнбуйр сум Нүхний булаг /сумын төвөөс баруун хойш 25 км /
5. Баянтүмэн сум Амгалан булаг /сумаас зүүн урагш 47 км/

Булгийн эхийг хашиж хамгаалах ажил хийх арга технологи, техникийн шаардлага

**1. Техникийн шийдэл**

Булгийн эхийг хашиж хамгаалахад дараах үндсэн шаардлагуудыг удирдлага болгохыг зөвлөж байна.

Үүнд:

1. Булгийн эх нь малын хөлөөс бүрэн хамгаалагдсан байх
2. Булгийн ундарга, эхийг хөндөж муутгахгүй байх
3. Булгийн ундаргад тулалт үүсгэхгүй байх
4. Төмөр хийц, материал сонгож бат бөх хийх
5. Хүйтний улиралд булгийг ашиглах боломжтой байх
6. Булгийн эхийг хамгаалахдаа нэг хийц загварыг сонгох

**1. Хамгаалах арга**

Булгийн эхийг хамгаалах хашааг  $24 \times 26\text{м}^2$  хэмжээтэй төмөр хийц материалаар нийт 100 метр урттай хийнэ. Булгийн ус цуглуулах талбайн хэмжээнээс хамааран хашааны хэлбэр 4 тал буюу тойрог байж болно. Хашааг  $1 \times 2 \text{ см}^2$  өргөн, хөндлөвчийг  $1 \times 4 \text{ см}^2$  хөндий төмрөөр гагнаж хийнэ.

Хашааны өндөр 120 см,

Шонгийн нийт урт 180 см

Шон хоорондын зай 200 см,

Хашааны сараалж хооронд 15 см,

Хашааны төмөр шонгийн диаметр 8-10 см-ийн голчтой төмөр трубагаар хийж, дээд талыг битүүлж, зэврэлтээс хамгаалж төмрийн будгаар будна. Шонг 50 см гүнд суулгаж, зэвэнд идэгдэж урвалд орохоос хамгаалан байгалийн чулуугаар чигжиж цементэлнэ.


Булгийн урсацын доод талд буюу булгийн хөлд 80 см өргөнтэй гадагш онгойдог, явган хаалга хийж хогийн сав байрлуулна.

Булгийн эхийг хамгаалсан хашаан дотор 10-аас доошгүй мод тарьсан байна.


Усны нөөцийг бохирдлоос хамгаалах талаарх сурталчилгааны самбарыг  $80 \times 60$  хэмжээтэй 2 мм зузаан гөлмөн төмрөөр хийж, хашаанд гагнаж бэхлэнэ.

Самбарт тавигдах мэдээллийг сайн чанарын гадна зориулалтын хэвлэл эсвэл гэрэл ойлгогчтой будаг ашиглаж хийнэ. Самбарын 2 талд мэдээллийг байрлуулна. Самбарт байрлуулах мэдээллийг Байгаль орчин, аялал жуулчлалын газраас авна.

БУЛАГ, РАШААНЫ ЭХИЙГ ХАШИЖ ХАМГААЛАХ, ТОХИЖУУЛАХ  
ХАШААНЫ ЗУРАГЛАЛ



/хашааны зураг/



/явган хүний хаалга/


**БУЛАГ, РАШААНЫ ЭХИЙГ ХАШИЖ, ТОХИЖУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР**  
/Матад сум Нарангийн булаг/

2019.02.19

Хэрлэн сум


№	Хийгдэх ажлууд	Тавигдах шаардлага
1	Рашааны эхийн хашааг сэргээн засварлах	-Рашааны эхийн хашааны суурийг сэргээн засварлаж, төмөр хашааны нурж унасан хэсгийг гагнаж, суурийн хэсгийг бөхөлж хийнэ. Өнгө үзэмжийг сайжруулан зориулалтын будгаар будна.
2	Рашаанд орох хэсэгт хамгаалалтын хашаа хийх	Хамгаалалтын хашаа нь 60х5 метрийн харьцаатай/130 метр урт/ өндөр нь 1.2 метр байна. Хашааны шонг 50 см гүнд суулгаж, цемент бетон зуурмагт суулгана.
3	Рашаанд орох хэсэгт сүүдрэвч, ширээ, сандал	-Сүүдрэвч нь 2х2.5 метрийн хэмжээтэй 1,8 метрийн өндөртэй 2 ширхэг байна. -Сүүдрэвчийг бат бөх төмрөөр хийж, газарт 0.5 м гүн цемент бетон зуурмагт суулгана. -Сүүдрэвчийн ширээг 1.0х0.6 метрийн харьцаатай төмрөөр хийж, газарт 50 см гүн цемент бетон зуурмагаар бэхлэн суулгана. -1 сүүдрэвчинд 1.0 метрийн урттай, 0.4 метрийн өргөнтэй 2 ширхэг сандал хийнэ. -Сүүдрэвч, сандал, ширээг төмрийн будгаар будна. -Сүүдрэвчийн дээврийг 0.6 мм зузаан дээврийн өнгөт төмрөөр хийнэ. -Сүүдрэвч, ширээ, сандал нь үйлчлүүлэгчдийн аюулгүй байдлыг хангасан хурц өнцөг, ирмэггүй байна.
6	Мэдээллийн самбар 2 ширхэг	-Рашааны эрүүл ахуйн болон хамгаалалтын бүсийн дэглэм, хог хаягдал, галын санамж байрлуулах мэдээллийн 2 ширхэг самбар хийнэ. - Самбарын хүрээг 20х40 мм тэгш өнцөгт төмрөөр гагнан хийж, 1000х1000 мм хэмжээтэй 2 мм зузаан гөлмөн төмрөөр битүүлж гагнаж бэхэлнэ. -Самбар нь 2 тулгуур багантай байна. Багана нь 2.5 метрийн урттай 80х80 мм квадрат төмрөөр хийж, самбарын хүрээтэй гагнаж бэхэлнэ. -Самбарын тулгуур баганыг газарт 50 см гүнд цемент бетон зуурмагт суулгана. Тулгуур баганы газарт суух хэсэгт

	<p>хөндлөвч төмөр гагнасан байна.</p> <p>- Самбарт тавигдах мэдээллийг сайн чанарын гадна зориулалтын хэвлэл эсвэл гэрэл ойлгогчтой будаг ашиглаж хийнэ. Самбарын 2 талд мэдээллийг байрлуулна.</p> <p>-Самбарт байрлуулах мэдээллийг Байгаль орчин, аялал жуулчлалын газраас авч бэлтгэн байрлуулна.</p>
--	---



Сүүдрэвчний хэмжээс

**БУЛАГ, РАШААНЫ ЭХИЙГ ХАШИЖ ХАМГААЛАХ, ТОХИЖУУЛАХ  
ХАШААНЫ ЗУРАГЛАЛ  
/Матад сум Нарангийн булаг/**



**/хашааны зураг/**

# Нарангийн рашааныг тохижуулах зураглал

